



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ (ТАВИЛГА)-ИЙН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ (БАГЦ-2)

2024 оны 7 дугаар сарын 16

СУГ/20240102063

Улаанбаатар хот

Нэг. Үндэслэл:

Засгийн газрын 2022 оны 492 дугаар тогтоол, Соёлын сайдын 2023 оны А/66 дугаар тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, урлагийн газрын бүтэц өөрчлөгдөн орон тоо нэмэгдэж зохион байгуулалт шинэчлэгдсэн.

Хоёр. Зорилго:

Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, албан хаагчдын ажиллах таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Худалдан авах бараа:

- Багц-2 Тавилга (Байгууллагын удирдлагын болон албан хаагчдын ширээ, сандал, файлын шүүгээ/хувцасны шүүгээ, сейф)

Дөрөв. Ерөнхий шаардлага:

- Тавилга нь өнгө үзэмж сайтай, тээвэрлэлтийн гэмтэлгүй, цоожтой, бүрэн бүтэн, шинэ байх
- Тавилгын үнийн дүнг тендерийн материалд хавсаргаж ирүүлэх
- Тавилгыг зөөж тээвэрлэх, заасан байршил, албан өрөөнүүдэд байршуулж, угсрах, суурилуулах явцад хөдөлмөрийн болон техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах
- Тавилгыг техникийн тодорхойлолт, шаардлагын дагуу нийлүүлж, захиалагчийн заасан газарт байршуулж, угсралт, тохируулгыг хийж гэрэл зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээлгэн өгөх

Тав. Үзүүлэлт, тодорхойлолт:

Багц 2. Тавилга.

Багц	Барааны нэр	Тоо, Ширхэг	Барааны тодорхойлолт, тайлбар
1	Ширээ Ажилтны ширээ (тумбочкатай заавал хамт)	30 ширхэг	Хэмжээ: урт- 140 см, өргөн-60см, өндөр-75см Хэлбэр: энгийн дөрвөлжин тавцантай Өнгө: цайвар /цагаан, саарал, шаргал/ Материал: хүний биед сөрөг нөлөөгүй, шахмал модон хавтан ДСП, ус чийгний хамгаалалттай Бусад/нэмэлт тайлбар/ ширээний үнэд тумбочканы үнэ багтсан байх
2	Удирдлагын ширээ	8 ширхэг	Хэмжээ: урт- 160 см, өргөн-80см, өндөр-75см Хэлбэр: Г хэлбэрийн буюу туслах ширээтэй байх Өнгө: Бор, хүрэн, цайвар Материал: Хүний биед сөрөг нөлөөгүй, шахмал модон хавтан ДСП, ус чийгний хамгаалалттай Бусад/нэмэлт тайлбар/: тумбочигтэй байх
3	Сандал	30 ширхэг	Хэмжээ: өргөн-50 см, өндөр-95см, гүн-50см Даац: 125кг Хэлбэр, загвар: нуруу амраагч түшлэгтэй, гарын түшлэгтэй, амьсгалдаг төрон нуруувчтай Өнгө: Цайвар, хар Материал: Даавуун, төрон Бусад/нэмэлт тайлбар/ хөл нь дугуйгүй, удаан суухад тохиромжтой
4	Файлын шүүгээ/хувцасны шүүгээ	19 ширхэг	Хэмжээ: Өргөн-90 см, өндөр-185см, гүн-50см Хэлбэр, загвар: Хувцас,файл хослуулан хадгалах боломжтой, цоожтой Өнгө: Цайвар / цагаан саарал, шаргал / Материал: Төмөр, модон

			<p>Бусад/нэмэлт тайлбар/ нүүр хэсэг шилтэй болон шилгүй байж болно.</p>
5	Сейф	2 жижиг 1 том	<p>Хэмжээ /жижиг/: Өргөн-70 см, өндөр-120см, гүн-65см эзэлхүүн-120л</p> <p>Хэмжээ /том/:</p> <p>Дотор тал: - өндөр-115см өргөн- 54см Гүн-42см</p> <p>Гадна тал: - 135см x 69см x 64см</p> <p>Эзэлхүүн : 260 л</p> <p>Хэлбэр, загвар: хурууны хээ, кодоор онгойдог, галт тэсвэртэй, тасалгаатай,</p> <p>Өнгө: Хар, саарал</p> <p>Бусад /нэмэлт тайлбар/ Хөл нь дугуйтай</p>